



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 30 өдөр

дугаар 29

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчit хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гүйцэтгэх захирлын 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 201 дугаар тушаал, "Монгол секюритис ҮЦК" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2015 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 05 тоот хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол секюритис ҮЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчit хувьцаат компанийтай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Монгол секюритис ҮЦК" ХХК /Л.Гүндэгмаа/-д анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д. АНГАР